



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 11 өдөр

Дугаар А/30

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сум дундын Ойн ангийн "Мод үржүүлгийн газар"-т шилмүүст болон навчит модны үр, мөчир үржүүлэх зуны хүлэмж худалдан авах ажил, Мод үржүүлгийн газрыг өргөтгөх ажилд дэмжлэг үзүүлэхэд үр, бордоо, усалгааны систем, хүлэмжийн хар тор, шаланк нийлүүлэх ажил, Хуш модны нөөц тогтооход шаардлагатай багаж тоног төхөөрөмж нийлүүлэх ажил, ой хээрийн түймэр хууль бус мод бэлтгэлээс урьдчлан сэргийлэх тэмцэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх, байгаль хамгаалагчдын ажлын хэрэгцээнд зургийн аппарат, өвөл, зуны хувцас нийлүүлэх зэрэг ажлуудын худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Очирхуяг (Сум дундын Ойн ангийн дарга)

Гишүүд: Б.Янжиндулам (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Ш.Бумандолгор (Ойн ангийн инженер)

2. Худалдан авах ажиллагааны техникийн тодорхойлолтыг боловсруулан 3-аас доошгүй иргэн, аж ахуйн нэгжээс үнийн санал авч нийлүүлэгчийг сонгон шалгаруулахыг Ажлын хэсгийн ахлагч (Д.Очирхуяг)-д даалгасугай.



ДАРГА

С.АМГАЛАН